



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 09 өдөр

Дугаар А/297

Газар өмчлүүлэх тухай

Монгол Улсын Иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 12 дугаар зүйлийн 12.1.3, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2 дахь заалт, Хаягжуулалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг, Жаргалант сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 6 дугаар сарын 24-ний 10 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 12 дугаар сарын 02-ны 8/06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эзэмшиж байгаа газраа өмчлөх хүсэлт ирүүлсэн 2 иргэнд дор дурдсан газруудыг үнэ төлбөргүйгээр өмчлүүлсүгэй.

| № | Өмчлөгчийн | | | | Газрын байршил | Газрын нийт хэмжээ | Метр квадратын үнэ | Газрын суурь үнэ |
|---|------------|------------------|-------------|----------------|--|--------------------|--------------------|------------------|
| | Овог | Эцэг/эх/-ийн нэр | Өөрийн нэр | Регистр дугаар | | | | |
| 1 | Шарынхан | Танк | Шонт | ПЮ76011172 | Буянт баг Жаргалант хайрхан 2-223 тоот | 1000,0 | 2500 | 2500000 |
| 2 | Төгсолхон | Ганболд | Жавзандулам | ПЭ85100929 | Баатархайрхан баг Дулааны 2-200 тоот | 897,0 | 2500 | 1060000 |

2. Хууль тогтоомжийн дагуу өмчилсөн газрын хил заагийг тэмдэгжүүлэн баталгаажуулахыг Жаргалант сумын Засаг дарга /Ц.Ганданповрон/, Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэл хийж, гэрчилгээ олгохыг Улсын бүртгэлийн хэлтэс /С.Хоролсүрэн/-т тус тус даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2005 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 128 дугаар захирамжийн 181,182 дахь заалтаар гэр бүлийн хэрэгцээнд хамтран газар өмчилсөн боловч хасах хэлцлээр нэрээ хасуулсан 182 дахь заалт буюу Т.Шонтод холбогдох хэсэг, аймгийн Засаг даргын

2007 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 82 дугаар захирамжийн 6 дахь заалтаар гэр бүлийн хэрэгцээнд хамтран газар өмчилсөн боловч хасах хэлцлээр нэрсээ хасуулсан Г.Эрдэнэбилэг, Г.Чанцалдулам, Г.Юмжирдулам, Г.Жавзандулам нарт холбогдох хэсгийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

